



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2025.02.05 № 02/147  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА  
Б.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг хүргүүлж байна.

Аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлэхийг зөвлөж байна.

Хавсралт . . . хуудастай.

ДЭД ДАРГА



Ч.БОЛД

02024379

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал .....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
5.1 Албан шаардлага.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДГ	Нийгмийн даатгалын газар
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
СХД НДГ	Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

᠒᠐2᠕. ᠐2. 2᠕ № ᠐1/1᠖᠖  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ГАЗРЫН ДАРГА  
Б.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сонгино хайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Аудитыг онцолсон хэсэг

Өмнөх оны аудитаар үндсэн хөрөнгөд тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох талаар холбогдох саналыг бэлтгэн холбогдох газарт хүргүүлж шийдвэрлүүлэх зөвлөмж өгснийг НДЕГ-т удаа дараа хүргүүлсэн боловч шийдвэрлээгүй байна.

### Аудитын гол асуудал

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасхалтгүй байх зарчмыг ашигласан байна. Ирээдүйн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад нөлөөлөх эргэлзээ төрүүлж байгаа байгаа нөхцөл байдал аудит хийх шалгалтын явцад илрээгүй ба материаллаг байдлын түвшинд хүрсэн алдаа зөрчил илрээгүй болно.

### Бусад асуудал

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.2 хувийн гүйцэтгэлтэй гэж НДЕГ-аас үнэлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>40,800,192.57</b>	<b>49,692,130.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>17,440.57</b>	
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	17,440.57	
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>40,782,752.00</b>	<b>49,692,130.00</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>40,782,752.00</b>	<b>49,692,130.00</b>
35410	Бичиг хэргийн материал	10,233,920.00	7,369,750.00
35420	Аж ахуйн материал	22,600,490.00	25,175,640.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,141,600.00	11,015,210.00
35470	Бусад хангамжийн материал	4,806,742.00	6,131,530.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,383,709,986.41</b>	<b>1,320,372,834.40</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,383,709,986.41</b>	<b>1,320,372,834.40</b>
<b>391</b>	<b>Газар</b>		<b>45,730,940.00</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,335,897,328.86</b>	<b>1,274,197,796.19</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,426,180,993.00	1,426,180,993.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(189,509,741.76)	(219,691,840.44)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	9,900,000.00	9,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(4,950,000.00)	(7,425,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	144,889,189.00	146,118,689.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(68,955,723.79)	(95,419,416.53)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	92,299,353.14	97,281,509.4
39208	Хуримтлагдсан элэгдэл	(73,956,740.73)	(82,747,137.98)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>47,812,657.55</b>	<b>444,098.21</b>
39301	Програм хангамж	6,661,500.00	6,661,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,579,782.45)	(6,217,401.79)
39303	Бусад биет бус хөрөнгө	45,730,940.00	
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,424,510,178.98</b>	<b>1,370,064,964.40</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>6,855,662.12</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>6,855,662.12</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	<b>6,855,662.12</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		1,749,889.40
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	5,105,772.72
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,424,510,178.98</b>	<b>1,363,209,302.28</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,424,510,178.98</b>	<b>1,363,209,302.28</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	315,243,460.10	315,243,460.10
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	315,243,460.10	315,243,460.10
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>859,209,777.29</b>	<b>797,908,900.59</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	859,209,777.29	859,209,777.29
51220	Тайлант үеийн үр дүн		(61,300,876.70)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	250,056,941.59	250,056,941.59
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,424,510,178.98</b>	<b>1,370,064,964.40</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,734,899,778.51</b>	<b>2,458,497,156.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,027,278.51</b>	<b>11,131,056.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>4,027,278.51</b>	<b>11,131,056.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,042,878.51	6,211,656.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	984,400.00	4,919,400.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1 730,872,500.00</b>	<b>2,447,366,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>		
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>7,999,500.00</b>	<b>2,447,366,100.00</b>
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		2,447,366,100.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,999,500.00	
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,722,873,000.00</b>	
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,722,873,000.00	
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,778,354,764.91</b>	<b>2,519,798,032.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,778,354,764.91</b>	<b>2,519,798,032.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,686,848,296.22</b>	<b>2,405,384,846.50</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,331,161,275.44</b>	<b>1,928,932,816.94</b>
210101	Үндсэн цалин	755,754,164.28	1,030,461,901.95
210102	Нэмэгдэл	192,135,618.92	295,688,089.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	175,908,192.61	282,404,915.28
210104	Урамшуулал	207,363,299.63	320,377,910.14
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>167,151,996.26</b>	<b>242,117,471.15</b>
210201	Тэтгэврийн даатгал	114,974,351.18	170,197,092.56
210202	Тэтгэмжийн даатгал	13,340,285.74	18,303,246.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,614,774.22	9,045,873.24
210204	Ажилгүйдлийн даатгал	2,494,733.16	8,664,524.96
210205	Эрүүл мэндийн даатгал	25,727,851.96	35,906,734.22
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>38,578,679.51</b>	<b>61,696,429.98</b>
210301	Гэрэл, цахилгаан	25,322,529.99	45,631,030.86
210302	Түлш, халаалт	8,822,071.26	11,419,561.90
210303	Цэвэр, бохир ус	4,434,078.26	4,645,837.22
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>27,062,437.10</b>	<b>32,105,642.42</b>
210401	Бичиг хэрэг	11,950,320.00	19,926,370.00
210402	Тээвэр, шатахуун	306,200.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,036,507.10	6,706,562.42
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,880,000.00	2,880,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,314,660.00	2,592,710.00
210408	Бараа материал акталсны зардал	574,750.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>19,824,300.00</b>	<b>39,693,280.00</b>

Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	2,332,400.00	8,974,490.00
210604	Урсгал засвар	17,491,900.00	30,718,790.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>23,869,425.00</b>	<b>28,378,398.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,579,600.00	6,600,280.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,600,000.00	16,721,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	389,100.00	490,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,984.00	59,984.00
210807	Газрын төлбөр	452,189.00	1,547,082.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	271,900.00	606,740.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,516,652.00	2,352,612.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>79,200,182.91</b>	<b>72,460,808.01</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	116,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,850,000.00	2,795,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	76,350,182.91	69,548,808.01
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>91,506,468.69</b>	<b>114,413,186.20</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>48,078,900.00</b>	<b>57,278,210.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,736,500.00	21,601,210.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,342,400.00	35,677,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>57,134,976.20</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	57,134,976.20
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>43,427,568.69</b>	<b>-</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	43,427,568.69	-
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(43,454,986.40)</b>	<b>(61,300,876.70)</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>		
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,069,674.73</b>	<b>-</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гаоз	3,069,674.73	
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(46,524,661.13)</b>	<b>(61,300,876.70)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,722,873,000.00</b>	<b>2,447,366,100.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,722,873,000.00</b>	<b>2,447,366,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>-</b>	<b>2,447,366,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	2,447,366,100.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>		
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,722,873,000.00</b>	<b>-</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,722,873,000.00	-
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,722,873,000.00</b>	<b>2,447,383,540.57</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,722,873,000.00</b>	<b>2,447,383,540.57</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,631,366,531.31</b>	<b>2,332,970,354.37</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,331,161,275.44</b>	<b>1,925,859,287.66</b>
210101	Үндсэн цалин	755,754,164.28	1,030,461,901.95
210102	Нэмэгдэл	192,135,618.92	295,688,089.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	175,908,192.61	282,404,915.28
210104	Урамшуулал	207,363,299.63	317,304,380.86
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>167,151,996.26</b>	<b>238,335,338.31</b>
210201	Тэтгэврийн даатгал	114,974,351.18	164,334,314.26
210202	Тэтгэмжийн даатгал	13,340,285.74	18,509,741.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,614,774.22	9,218,521.10
210204	Ажилгүйдлийн даатгал	2,494,733.16	9,043,184.90
210205	Эрүүл мэндийн даатгал	25,727,851.96	37,229,576.06
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>38,578,679.51</b>	<b>61,696,429.98</b>
210301	Гэрэл, цахилгаан	25,322,529.99	45,631,030.86
210302	Түлш, халаалт	8,822,071.26	11,419,561.90
210303	Цэвэр, бохир ус	4,434,078.26	4,645,837.22
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>48,025,907.10</b>	<b>29,423,302.42</b>
210401	Бичиг хэрэг	14,028,200.00	14,668,880.00
210402	Тээвэр, шатахуун	306,200.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,036,507.10	6,706,562.42
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,880,000.00	2,880,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,775,000.00	5,167,860.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>20,295,900.00</b>	<b>46,324,890.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,804,000.00	15,606,100.00
210604	Урсгал засвар	17,491,900.00	30,718,790.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>23,302,773.00</b>	<b>28,419,106.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,529,600.00	8,993,600.00



Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,600,000.00	16,721,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	389,100.00	490,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,984.00	59,984.00
210807	Газрын төлбөр	452,189.00	1,547,082.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	271,900.00	606,740.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,850,000.00</b>	<b>2,912,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	116,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,850,000.00	2,795,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>91,506,468.69</b>	<b>114,413,186.20</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>48,078,900.00</b>	<b>57,278,210.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,736,500.00	21,601,210.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,342,400.00	35,677,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>57,134,976.2</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		57,134,976.2
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>43,427,568.69</b>	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	43,427,568.69	-
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	-	<b>(17,440.57)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	-	<b>(17,440.57)</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<b>17,440.57</b>	<b>17,440.57</b>
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>17,440.57</b>	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	315,243,460.10	250,056,941.59	905,734,438.42	1,471,034,840.11
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	315,243,460.10	250,056,941.59	905,734,438.42	1,471,034,840.11
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Өмчид гарсан өөрчлөлт				
8	Зарласан ногдол ашиг				
9	Тайлант үеийн үр дүн			(46,524,661.13)	(46,524,661.13)
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	315,243,460.10	250,056,941.59	859,209,777.29	1,424,510,178.98
11	2024 оны 1-р сарын 1- нээрх үлдэгдэл	315,243,460.10	250,056,941.59	859,209,777.29	1,424,510,178.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	315,243,460.10	250,056,941.59	859,209,777.29	1,424,510,178.98
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Өмчид гарсан өөрчлөлт				
18	Зарласан ногдол ашиг				
19	Тайлант үеийн үр дүн			(61,300,876.70)	(61,300,876.70)
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	315,243,460.10	250,056,941.59	797,908,900.59	1,363,209,302.28

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,447,366,100.00</b>	<b>2,390,248,564.37</b>	<b>57,117,535.63</b>	<b>97.7</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,447,366,100.00</b>	<b>2,390,248,564.37</b>	<b>57,117,535.63</b>	<b>97.7</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,390,086,300.00</b>	<b>2,332,970,354.37</b>	<b>57,115,945.63</b>	<b>97.6</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,947,427,900.00</b>	<b>1,925,859,287.66</b>	<b>21,568,612.34</b>	<b>99.9</b>
Үндсэн цалин	1,037,274,100.00	1,030,461,901.95	6,812,198.05	99.3
Нэмэгдэл	307,380,400.00	295,688,089.57	11,692,310.43	96.2
Унаа хоолны хөнгөлөлт	312,998,400.00	282,404,915.28	30,593,484.72	90.2
Урамшуулал	289,775,000.00	317,304,380.86	(27,529,380.86)	109.5
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>249,186,400.00</b>	<b>238,335,338.31</b>	<b>10,851,061.69</b>	<b>95.7</b>
Тэтгэврийн даатгал	171,311,000.00	164,334,314.26	6,976,685.74	95.9
Тэтгэмжийн даатгал	19,468,900.00	18,509,741.99	959,158.01	95.1
ҮОМШӨ-ний даатгал	9,734,400.00	9,218,521.10	515,878.90	94.7
Ажилгүйдлийн даатгал	9,734,400.00	9,043,184.90	691,215.10	92.9
Эрүүл мэндийн даатгал	38,937,700.00	37,229,576.06	1,708,123.94	95.6
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>83,319,200.00</b>	<b>61,696,429.98</b>	<b>21,622,770.02</b>	<b>74.1</b>
Гэрэл, цахилгаан	52,444,200.00	45,631,030.86	6,813,169.14	87.1
Түлш, халаалт	25,397,600.00	11,419,561.90	13,978,038.10	44.1
Цэвэр, бохир ус	5,477,400.00	4,645,837.22	831,562.78	84.8
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>29,481,700.00</b>	<b>29,423,302.42</b>	<b>58,397.58</b>	<b>99.8</b>
Бичиг хэрэг	14,775,600.00	14,668,880.00	106,720.00	99.3
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,564,300.00	6,706,562.42	(142,262.42)	102.2
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,880,000.00	2,880,000.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,261,800.00	5,167,860.00	93,940.00	98.2
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>46,341,100.00</b>	<b>46,324,890.00</b>	<b>16,210.00</b>	<b>100.0</b>
Багаж, техник, хэрэгсэл	15,606,100.00	15,606,100.00	-	100.0
Урсгал засвар	30,735,000.00	30,718,790.00	16,210.00	100.0
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,883,800.00</b>	<b>-</b>	<b>2,883,800.00</b>	<b>-</b>
Дотоод албан томилолт	2,883,800.00	-	2,883,800.00	-
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>28,534,200.00</b>	<b>28,419,106.00</b>	<b>115,094.00</b>	<b>99.6</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,993,900.00	8,993,600.00	300.00	100.0

Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	16,721,200.00	16,721,200.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	490,500.00	490,500.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	98,100.00	59,984.0	38,116.00	61.2
Газрын төлбөр	1,547,100.00	1,547,082.00	18.00	100.0
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	683,400.00	606,740.0	76,660.00	88.8
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,912,000.00</b>	<b>2,912,000.00</b>		<b>100.0</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	116,200.00	116,200.00		100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,795,800.00	2,795,800.00		100.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>57,279,800.00</b>	<b>57,278,210.00</b>	<b>1,590.00</b>	<b>100.0</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>57,279,800.00</b>	<b>57,278,210.00</b>	<b>1,590.00</b>	<b>100.0</b>
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	21,602,800.00	21,601,210.00	1,590.00	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,677,000.00	35,677,000.00	-	100.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,447,366,100.00</b>	<b>2,390,231,123.80</b>	<b>57,134,976.20</b>	<b>97.7</b>
Улсын төсвөөс санхүүжих	2,447,366,100.00	2,390,231,123.80	57,134,976.20	97.7
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>129</b>	<b>127</b>		<b>98.5</b>
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>		<b>100.0</b>
Төсвийн байгууллага	1	1		100.0
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>64</b>	<b>63</b>		<b>98.4</b>
Удирдах ажилтан	7	7		100.0
Гүйцэтгэх ажилтан	51	50	1	98.0
Үйлчлэх ажилтан	6	6	-	100.0
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>64</b>	<b>63</b>	<b>1</b>	<b>98.4</b>
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	49	48	1	98.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15	15	-	100.0

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2023 оны А/169 тоот тушаалаар 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газар болж өөрчлөгдсөн байна.

Тус газар нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо "Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг өөрийн харьяа нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих, даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх" гэж тодорхойлжээ. Тус газар нь тайлант онд дараах 5 зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Иргэд даатгуулагчдад үзүүлэх нийгмийн даатгалын үйлчилгээг ил тод шуурхай байх;
- Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх;
- Ажилтан албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх;
- Даатгуулагчдад үзүүлэх нийгмийн даатгалын цахим үйлчилгээг чанаржуулах;
- Чанарын менежментийн тогтолцоонд ISO 9001:2015 (MNS ISO 9001:2016) стандартын дагуу аудитын дахин магадлалыг амжилттай дүгнүүлэх зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Тус газар нь харьяа дүүргийн ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэл болон хуульд заасан бусад эх үүсвэрээр нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг бүрдүүлж, даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох үйл ажиллагааг гүйцэтгэдэг.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

СХД НДГ нь Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлд хяналт тавих, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг тогтоож, хуулиар тогтоосон хугацаанд олгох, иргэд даатгуулагчид нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, үйл ажиллагаа явуулдаг, НДЕГ-ын харьяа байгууллага юм.

Ажил олгогч байгууллага, иргэд даатгуулагчдаас хууль тогтоомжид заасан хувь хэмжээний дагуу нийгмийн даатгалын шимтгэлийг төвлөрүүлж, тэтгэвэр, тэтгэмж, ҮОМШӨ, эрүүл мэндийн бэлон ажилгүйдлийн гэсэн 5 сангийн орлогыг бүрдүүлж, хуулийн дагуу эрх үүссэн даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж олгох ажлыг хийж гүйцэтгэж байна.

Үйл ажиллагаандаа Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон нийгмийн даатгалын бусад багц хуулиуд, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Хөдөлмөрийн тухай, , Татварын тухай , Захиргааны ерөнхий, Шилэн дансны тухай хууль хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэр, журмуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд тус газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Захиргааны ерөнхий хууль /2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн өдөр нэмэлт өөрчлөлт/;
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль /2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн өдөр/;
- Төсвийн тухай хууль /2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн өдөр нэмэлт өөрчлөлт/;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль /2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон/;
- Хөдөлмөрийн тухай хууль /2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр нэмэлт өөрчлөлт/;
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны А/88 тоот тушаал "Унаа хоолны нөхөх төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай";
- Сонгинохайрхан дүүргийн нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны А/09 дүгээр тушаал "Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн батлах тухай";

Тус газрын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Захиргаа хяналтын хэлтэс нь гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн тайланг ирүүлж 6 зөвлөмж, 70 акт арга хэмжээ авсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

СХД НДГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

НДЕГ-ын даргын 2022 оны 04 сарын 11 өдрийн А/64 тоот тушаалаар "Нийгмийн даатгалын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, НДЕГ-ын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/243 дугаар тушаалаар "Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг тус тус батлан мөрдөн ажиллаж байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

СХД НДГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,370,065.0 мянган төгрөгөөр буюу 3.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	17.4	-	-
Бараа материал	40,782.8	49,692.1	8,909.4
Үндсэн хөрөнгө	1,383,710.0	1,320,372.8	(63,337.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,424,510.2</b>	<b>1,370,065.0</b>	<b>(54,445.2)</b>
Өр төлбөр		6,855.7	6,855.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	315,243.5	315,243.5	
Хуримтлагдсан үр дүн	859,209.8	797,908.9	(61,300.9)
Дахин үнэлгээний зөрүү	250,056.9	250,056.9	
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,424,510.2</b>	<b>1,370,065.0</b>	<b>(54,445.2)</b>

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгө, өр, төлбөр, данс байна. Үүнд:

Тайлант онд ахмадын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 17.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 49,692.1 мянган төгрөг болж өмнөх оноос 8,909.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь дулааны сантехникийн шугам хоолойн засварын материал худалдан авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,320,372.8 мянган төгрөг болж өмнөх оноос 63,337.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант жилд байгуулсан элэгдлээс шалтгаалсан байна.

Өр төлбөр тайлант онд 6,855.7 мянган төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг төлөөгүйтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо тайлант онд 315,243.5 мянган төгрөг болж өмнөх оноос өөрчлөлт ороогүй байна.

Тайлант онд нийт хөрөнгө 1,370,065.0 мянган төгрөг болж өмнөх оноос 54,445.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд байгуулагдсан үндсэн хөрөнгийн элэгдлээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус газрын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,382,208.2 мянган төгрөг, нийт зарлагыг 2,382,208.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас бараа үйлчилгээний зардлыг 274,070.9 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэгийн зардлыг 1,624.5 мянган төгрөгөөр бууруулж, 2,106,512.8 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг

бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй, цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас шалтгаалсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 340,853.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нийгмийн даатгалын 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,447,366.1 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,447,336.1 мянган төгрөгийн санхүүжилт олгож, зарцуулагдаагүй санхүүжилтийн үлдэгдэл 57,117.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,390,248.6 мянган төгрөг буюу 97.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 57,117.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71901-Нийгмийн даатгал	2,447,366.1	2,390,248.6	57,117.5	97.7
1.1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	2,218,840.3	2,189,510.3	29,330.0	98.7
1.2	80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	41,580.0	25,889.1	15,690.9	62.3
1.3	80213 Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн үйлчилгээ	294.3	294.3		100.0
1.4	80219 Харуул, хамгаалалтын зардал	5,199.6	5,199.3	0.3	100.0
1.5	80224 Зөвлөл, хороо, комиссын гишүүд	124,172.1	112,077.3	12,094.8	90.3
1.6	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	35,677.0	35,677.0		100.
1.7	80813 Хуульд заасан үндэслэлээр алба хаагчдад олгох тэтгэмж, урамшуулал	2,746.8	2,745.9	0.9	100.0
1.8	80820 Ажил олгогчоос олгох бусад тусламж, дэмжлэг	18,856.0	18,855.3	0.7	100.0

Баталсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

#### Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

д/д	Худалдан авах ажиллагаа	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Цэвэр бохир ус	5,477.4	4,645.8	831.6	84.8
2	Түлш халаалт	25,397.6	11,419.6	13,978.0	45.0
3	Гэрэл цахилгаан	52,444.2	45,631.0	6,813.2	87.0
4	Бичиг хэрэг	14,775.6	14,668.9	106.7	99.3
5	Шуудан холбоо интернэтийн зардал	6,564.3	6,706.6	- 142.3	102.2
6	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	5,261.8	5,167.9	93.9	98.2



Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

7	Хог хаягдал зайлуулах, хортон хортон мэрэгчдийн устгал ариутгал	2,880.0	2,880.0	-	100.0
8	Урсгал засвар	30,735.0	30,718.8	16.2	100.0
9	Багаж, техник, хэрэгсэл	15,606.1	15,606.1	-	100.0
10	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,993.9	8,993.6	0.3	100.0
11	Аудит, баталгаажуулалтын үйлчилгээний хураамж	16,721.2	16,721.2	-	100.0
12	Бараа үйлчилгээний бусад зардал	116.2	116.2	-	100.0
13	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,795.8	2,795.8	-	100.0
14	<b>Нийт</b>	<b>187,769.1</b>	<b>166,071.4</b>	<b>21,697.7</b>	<b>88.4</b>

Тус газар нь тайлант онд худалдан авах үйл ажиллагаанд тендер зарлаагүй, цахим дэлгүүрээс худалдан авалт хийх шаардлага үүсээгүй бөгөөд хангамжийн материалыг шууд гэрээгээр худалдан авсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Сонгинохайрхан дүүргийн нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад Төсвийг зохистой удирдаж, өр төлбөр үүсгэхгүй ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Си Эс Ай Аудит ХХК-ийн Ахлах аудитор Г.Должинсүрэн, аудитор Б.Отгончимэг, С.Цэнд-Аюуш, С.Содномцэрэн, нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Чулуунбат, захирал М.Сэвжидмаа НТАГ-ын СНАХ-ийн аудитын менежер С.Гантөгс, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, дэд дарга Ч.Болд нар хэрэгжүүлсэн.

СХД НДГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 84 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,778,354.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 17,783.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага болон дээд шатны төсвийн захирагчаас төрийн хэмнэлттэй холбоотой тушаал, шийдвэр гарах, арга хэмжээ авах нөхцөл байдал үүсээгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь 2024 онд цалин хөлсний зардлыг 21,568.7 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 10,851.1 мянган төгрөг, ашиглалтын зардлыг 21,622.8 мянган төгрөг, томилолтын зардлыг 2,883.8 мянган төгрөг, бусад зардлыг 189.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэж арга хэмжээ авч ажилласан байна. Тус байгууллага нь авто тээврийн хэрэгслийг тайлант онд хэрэглээгүй, шатахууны зардал гаргаагүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн

асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

СХД НДГ-ын шилэн дансны цахим системд 2024 онд 2,447,366.1 мянган төгрөгийн 147 мэдээлэл байршуулахаас 145 мэдээллийг байршуулж, мэдээллийг бүрэн байршуулсан бөгөөд 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

Нийцлийн асуудлаар илэрсэн 1 зөрчил илэрч, 1 зөвлөмж өглөө.

**Илрүүлэлт:** УСНББОУС-д өөрчлөлт орсноор Сангийн сайдын 2006 оны 388-р тушаал хүчингүй болж өөрчлөгдсөн байхад байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2-т “*Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах*” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах.

### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, нийт зардлын дансны хувьд горим, сорил хэрэгжүүлж, нийт 101,379.5 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчлийг илрүүлж, шалгагдагч байгууллагад асуудлын бүртгэлээр танилцуулж, жилийн эцсийн аудитаар үнэлсэн.

#### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар 718,304.0 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2024 оны 150 дугаар албан бичгээр Нийслэл дэх төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Хэрэгжилтийн тайлан, нотлох баримтыг 2024 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн 549 дугаар албан бичгээр ирүүлсэн бөгөөд 5 зөвлөмж өгснийг 96.0 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	5	718,304.0	5	718,304.0	96.0
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>718,304.0</b>	<b>5</b>	<b>718,304.0</b>	<b>96.0</b>

Урд онуудад хэрэгжээгүй төлбөрийн актууд байхгүй байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус газрын үндсэн хөрөнгөд тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох талаар холбогдох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлсэн эсэхийг шалгах.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 11,272.8 мянган төгрөгийн 3 зөрчлийг<sup>1</sup> илрүүлж, зөрчлийг арилгуулах 11,272.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 11,272.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 6,510.7 мянган төгрөгөөр бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

#### 5.1 Албан шаардлага

**Илрүүлэлт 1:** Тайлант онд албан хаагчдад үр дүнгийн 11,272.8 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх; 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Үр дүнгийн урамшууллыг холбогдох хуулийн дагуу олгоогүй зөрчлийг зогсоож, цаашид давтан гаргахгүйа жиллах албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 2:** НДЕГ-ын 2024 оны "Бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай" А/52 дугаар тушаалаар СХД-ийн НДГ-ыг нийт 64 орон тоотой байхаар баталсан боловч тэтгэврийн байцаагч 4, тэтгэмжийн байцаагч 3, хяналтын байцаагч 1, нийт 8 орон тоо илүү ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16 дугаар зүйлийн 16.5.9-т "Дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар,

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Батлагдсан орон тоонд ажлаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

## **5.2 Зөвлөмж**

**Илрүүлэлт:** Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн 6,855.7 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төсвийг зохистой удирдаж, өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

Дээрх албан шаардлагыг биелүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуульд заасан хугацаанд гарган, Нийслэл дэх төрийн аудитын газарт ирүүлж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2025 оны 08 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд албан хаагчдад үр дүнгийн 11,272.8 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.	1	11,272.8			1	11,272.8						
НДЕГ-ын 2024 оны "Бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай" А/52 дугаар тушаалаар СХД-ийн НДГ-ыг нийт 64 орон тоотой байхаар баталсан боловч тэтгэврийн байцаагч 4, тэтгэмжийн байцаагч 3, хяналтын байцаагч 1, нийт 8 орон тоо илүү ажилласан байна.	1	-			1	-						
Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн 6,855.7 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.							1	-				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>11,272.8</b>			<b>2</b>	<b>11,272.8</b>	<b>1</b>	<b>-</b>				

Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Дүн						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
УСНББОУС-д өөрчлөлт орсон, Сангийн сайдын 388-р тушаал хүчингүй болж өөрчлөгдсөн боловч нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулаагүй байна.	1	-			1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>			<b>1</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>-</b>			<b>1</b>	<b>-</b>



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 40/12590546

Улаанбаатар хот

ХТАС-2024/589 /НА-СТН-ТӨМ?

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд албан хаагчдад үр дүнгийн 11,272.8 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1.Төсвийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар1т ирүүлэх;

2.Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга Б.Жаргалсайхан, санхүү бүртгэлийн тасгийн дарга, ахлах нягтлан бодогч Х.Эрдэнэтуяа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:**

СИ ЭС АЙ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ АУДИТОР

М.СЭВЖИДМАА

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН  
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

ХЯНАСАН

С.ГАНТӨГС







НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 41/14510546

Улаанбаатар хот

НТАГ - 2025/589/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны "Бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай" А/52 дугаар тушаалаар тус газрыг нийт 64 орон тоотой байхаар баталсан боловч тэтгэврийн байцаагч 4, тэтгэмжийн байцаагч 3, хяналтын байцаагч 1, нийт 8 орон тоо илүү ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16 дугаар зүйлийн 16.5.9-т "Дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох". Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө". Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлуулан, батлагдсан орон тоонд багтаан ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга Б.Жаргалсайхан, санхүү бүртгэлийн тасгийн дарга, ахлах нягтлан бодогч Х.Эрдэнэтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:

СИ ЭС АЙ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ АУДИТОР

М.СЭВЖИДМАА

ХЯНАСАН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН  
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

С.ГАНТӨГС